

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerquibaatar@audit.gov.mn

Аудитор С.Оргил
Утас: 77665858

Цахим хаяг: Shinjenmagadlahui.ezsh.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.02.25 № 102
танай _____-ны № _____-г

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРДЭНЭБУЛГАН
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ЭНХТУУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1-р цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд нийт 10 арга хэмжээнд төсвөөс 1,075,509.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 965,271.1 мянган төгрөгийг зарцуулж, 107,188.4 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын хүүхдийн цэцэрлэгийн 1-р цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын 103 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хэрэгжилтийг 100.0 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	199,099,163.37	204,359,968.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	113,118,168.17	107,188,395.29
312	Банканд байгаа бэлэн мөнгө	113,118,168.17	107,188,395.29
3121	Төгрөг	113,118,168.17	107,188,395.29
31211	Төрийн сангийн харилцах	113,118,168.17	107,188,395.29
35	БАРАА МАТЕРИАЛ	53,323,462.0	97,171,572.84
351	Түүхий эд материал	697,500.00	798,500.00
3513	Эм боох материал	697,500.00	798,500.00
354	Хангамжийн материал	85,283,495.20	96,373,072.84
3541	Бичиг хэргийн материал	776,112.00	1,040,600.00
3542	Аж ахуйн материал	82,359,083.20	95,332,472.84
35470	Бусад хангамжийн материал	2,148,300.00	-
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	311,248,080.62	349,549,682.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	311,248,080.62	349,549,682.07
392	Биет хөрөнгө	265,828,080.62	304,129,682.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	247,098,738.66	262,023,738.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	-28,802,495.40	-34,829,293.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,988,239.80	77,110,689.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,437,968.00	-24,006,518.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,444,000.00	28,614,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,596,334.44	-10,969,584.26
39217	Ном	3,940,000.00	3,070,750.00
393	Биет бус хөрөнгө	45,420,000.00	45,420,000.00
39301	Программ хангамж	490,000.00	490,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-490,000.00	-490,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	45,420,000.00	45,420,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	510,347,243.99	553,909,650.20
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	510,347,243.99	553,909,650.20
51	Засгийн газрын хувь оролцоо	510,347,243.99	553,909,650.20
512	Хуримтлагдсан үр дүн	1,852,681,150.91	-433,334,546.00
5121	Өмнөх үеийн үр дүн	-476,896,952.21	-476,896,952.21
5122	Тайлант үеийн үр дүн	-	43,562,406.21
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	987,244,196.20	987,244,196.20
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	510,347,243.99	553,909,650.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	789,443,519,80	1,001,766,100,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,011,619,80	42,689,400,00
120	Нийтлэг татварын бус орлого	25,011,619,80	42,689,400,00
120017	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,880,000,00	39,374,400,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000,00	3,315,000,00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,705,000,00	39,374,400,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	513,817,800.0	673,366,300.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	664,905,500,00	842,231,300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	664,905,500,00	842,231,300,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,526,400,00	116,845,400,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	99,526,400,00	116,845,400,00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	687,187,112,24	957,013,244,25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,187,112,24	957,013,244,25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	681,712,501,88	941,969,562,21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,427,812,94	642,634,772,88
210101	Үндсэн цалин	296,867,322,94	431,143,405,88
210102	Нэмэгдэл	98,041,090,00	178,973,131,00
210104	Урамшуулал	19,519,400,00	32,518,236,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,607,771,28	82,326,700,00
210201	Тэтгэврийн даатгал	38,878,273,32	55,982,200,00
210202	Тэтгэмжийн даатгал	4,519,453,50	6,586,200,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,614,783,78	3,293,000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	872,483,68	3,293,000,00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,722,777,00	13,172,300,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,516,389,64	87,591,017,96
210301	Гэрэл, цахилгаан	4,659,299,64	5,552,524,00
210302	Түлш, халаалт	75,168,520,00	75,168,512,00
210303	Цэвэр, бохир ус	6,688,570,00	6,869,981,96
2104	Хангамж, бараа материалын зардал	14,718,835,90	2,148,300,00
210401	Бараа материал акталсны зардал	14,718,835,90	2,148,300,00
2105	Нормативт зардал	66,695,401,00	76,601,512,00
210502	Хоол, хүнс	66,695,401,00	76,601,512,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,366,000,00	5,049,336,00
210604	Урсгал засвар	8,366,000,00	5,049,336,00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,004,500,00	2,523,800,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,004,500,00	2,523,800,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,375,791,12	43,094,123,37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,168,600,00	15,525,889,36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,093,100,00	4,447,985,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,114,091,12	23,120,249,01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,474,610,36	15,043,682,04
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,849,600,00	11,993,300,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,849,600,00	11,993,300,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,625,010,36	3,050,382,04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,625,010,36	3,050,382,04
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	102,256,407,56	44,752,855,75
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,190,449,54
КТ(225001)	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		-1,190,449,54
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	102,256,407,56	43,562,406,21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	764,606,900.00	962,31,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,000,00	3,315,000,00
120	Нийтлэг татварын бус орлого	175,000,00	3,315,000,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	175,000,00	3,315,000,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	175,000,00	3,315,000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	764,431,900,00	959,076,700,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	664,905,500,00	842,231,300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	664,905,500,00	842,231,300,00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	99,526,400,00	116,845,400,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	99,526,400,00	116,845,400,00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	658,714,549,22	945,083,572,88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	658,714,549,22	945,083,572,88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	434,627,423.04	626,395,302.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,427,812,94	642,634,772,88
210101	Үндсэн цалин	296,867,322,94	431,143,405,88
210102	Нэмэгдэл	98,041,090,00	178,973,131,00
210104	Урамшуулал	19,519,400,00	32,518,236,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,607,771,28	82,326,700,00
210201	Тэтгэврийн даатгал	38,878,273,32	55,982,200,00
210202	Тэтгэмжийн даатгал	4,519,453,50	6,586,200,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,614,783,78	3,293,000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	872,483,68	3,293,000,00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,722,777,00	13,172,300,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,516,389,64	87,591,017,96
210301	Гэрэл, цахилгаан	4,659,299,64	5,552,524,00
210302	Түлш, халаалт	75,168,520,00	75,168,512,00
210303	Цэвэр, бохир ус	6,688,570,00	6,869,981,96
2105	Нормативт зардал	65,913,965,00	76,866,000,00
210502	Хоол, хүнс	65,913,965,00	76,866,000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,385,000,00	11,279,000,00
210604	Урсгал засвар	11,385,000,00	11,279,000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,184,500,00	2,630,200,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,184,500,00	2,630,200,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,204,500,00	26,712,200,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,651,000,00	21,183,800,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,553,500,00	5,528,400,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,474,610,36	15,043,682,04
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,849,600,00	11,993,300,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,849,600,00	11,993,300,00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,625,010,36	3,050,382,04
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,625,010,36	3,050,382,04
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	105,892,350.78	17,308,127.82
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-3,184,600,00	-23,237,900,00
	Дотоод эх үүсвэрээр	-3,184,600,00	-23,237,900,00

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-3,184,600,00	-23,237,900,00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-3,184,600,00	-23,237,900,00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	102,707,750,78	-5,929,772,88
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,410,417,39	113,118,168,17
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	113,118,168,17	107,188,395,29

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	987,244,196,20		-476,896,52,21	510,347,243,99
9	Тайлант үеийн үр дүн	-	-	43,562,406,21	43,562,406,21
10	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	987,244,196,20		-433,334,546,00	553,909,650,20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,075,509,700.00	965,271,090.84	110,238,609.16	89.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,075,509,700.00	965,271,090.84	110,238,609.16	89.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,063,516,400.00	953,277,790.84	110,238,609.16	89.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	733,895,800.00	642,634,772.88	91,261,027.12	87.6
210101	Үндсэн цалин	523,339,700.00	431,143,405.88	92,196,294.12	82.4
210102	Нэмэгдэл	193,820,900.00	178,973,131.00	14,847,769.00	92.3
210104	Урамшуулал	16,735,200.00	32,518,236.00	-15,783,036.00	194.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,352,700.00	82,326,700.00	3,026,000.00	96.5
210201	Тэтгэврийн даатгал	58,041,400.00	55,982,200.00	2,059,200.00	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	6,826,700.00	6,586,200.00	240,500.00	96.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,414,000.00	3,293,000.00	121,000.00	96.5
210204	Ажилгүйдлийн даатгал	3,414,000.00	3,293,000.00	121,000.00	96.5
210205	Эрүүл мэндийн даатгал	13,656,600.00	13,172,300.00	484,300.00	96.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,641,400.00	87,591,017.96	4,050,382.04	95.6
210301	Гэрэл, цахилгаан	5,830,900.00	5,552,524.00	278,376.00	95.2
210302	Түлш, халаалт	76,168,500.00	75,168,512.00	999,988.00	98.7
210303	Цэвэр, бохир ус	9,642,000.00	6,869,981.96	2,772,018.04	71.3
2105	Нормативт зардал	87,379,300.00	76,886,000.00	10,493,300.00	88.0
210502	Хоол, хүнс	87,379,300.00	76,886,000.00	10,493,300.00	88.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,204,000.00	26,204,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	26,204,000.00	26,204,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,630,200.00	2,630,200.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,630,200.00	2,630,200.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	37,413,000.00	35,025,100.00	2,387,900.00	93.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,366,600.00	26,978,700.00	2,387,900.00	91.9

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,046,400.00	8,046,400.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,993,300.00	11,993,300.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,993,300.00	11,993,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,993,300.00	11,993,300.00	0.00	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,075,509,700.00	959,341,317.96	116,168,382.04	89.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	842,231,300.00	842,231,300.00	0.00	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	842,231,300.00	842,231,300.00	0.00	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	116,845,400.00	113,795,017.96	3,050,382.04	97.4
132001	Орон нутгийн төсвөөс	116,845,400.00	113,795,017.96	3,050,382.04	97.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	116,433,000.00	3,315,000.00	113,118,000.00	2.8
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,315,000.00	3,315,000.00	0.00	100.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	113,118,000.00		113,118,000.00	0.0
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		113,118,168.17	-	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		107,188,395.29	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	29.00	29.00	0.00	100.0
6	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.0
7	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	0.00	100.0
8	Үйлчлэх ажилтан	11.00	11.00	0.00	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 1 зөрчил¹ илэрсэн бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүллээ. Аудитаар илэрсэн зөрчил нь материаллаг бус байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1. Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон ахуйн хэрэгслийн орлого, зардлын бүртгэл тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан жагсаалтын дагуу эцэг, эх, асран хамгаалагчдаас хүлээн авсныг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүүхдийн хичээлийн хэрэглэл, сургалтын болон эрүүл ахуйн хэрэгслийг хүлээн авсан үед бараа материалын зохих дансанд орлогоор, сургалтын үйл ажиллагаанд

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тавьж олгосон тухай бүр зардлаар бүртгэж бараа материалын тайлан бэлтгэж үр дүнг
санхүүгийн тайланд тусгаж, мэдээлэх арга хэмжээ авч ажиллах

*Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал
илэрхийлье.*

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалтай холбоотой	1	0					1	0				
Дүн	1	0					1	0				